ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРОО

30 ЖИЛ

# NATIONAL ANTI-FRAUD SYSTEM (NAS)

ЗГ, ТХТ-ийн мэргэжилтэн Ц.Нямсүрэн

# АГУУЛГА

## 01 ЗАЛИЛАНГИЙН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

- Өнөөгийн нөхцөл байдал
- Залилангийн эсрэг бодлого, чиг хандлага

## 02 ЗАЛИЛАНГИЙН ЭСРЭГ ҮНДЭСНИЙ НЭГДСЭН СИСТЕМ (NAS)

- National anti-fraud system
- Монгол Улсад хэрэгжүүлэх NAS-ийн туршилтын загвар (POC)
- Монгол Улсад хэрэгжүүлэх IM Deactivation шийдлийн туршилтын загвар (POC )

# ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

## ЗАЛИЛАН -ДЭЛХИЙН ХЭМЖЭЭНИЙ АЮУЛ

**Кибер гэмт хэргийн** (цахим орчинд эсвэл сүлжээнд холбогдсон төхөөрөмжөөр хийгдэх гэмт хэрэг) үүнд залилан орно, дэлхийн хэмжээнд учруулах санхүүгийн хохирлын хэмжээ 2024 онд **9.22 их наяд ам.доллар** байгаа бол 2029 он гэхэд **15.63 их наяд ам.доллар** хүртэл өсөхөөр төлөвлөгдөж байна. *(Statista[1])*

2023 оны эцсийн байдлаар дэлхий даяар **5.6 тэрбум хүн** (хүн амын 69%) гар утасны үйлчилгээ ашиглаж, **4.7 тэрбум хүн** (хүн амын 58%) мобайл интернет хэрэглэж байна (*GSMA Mobile Economy Report*, 2024[2]).

2023 онд гэмт хэрэгтнүүд хорирогчдод **1 их наяд ам.долларааc** давсан хохирол учруулжээ. *(Global Anti-Scam Alliance[3])*

Дэлхийн байгууллагуудын **71%** нь 2023 онд и-мэйл дээр суурилсан **Phishing** халдлагад дор хаяж нэг удаа өртсөн байна. (*Proofpoint's 2023 State of the Phish Report[4]*)

# ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

## ЗАЛИЛАНГИЙН НИЙТЛЭГ ТӨРЛҮҮД

**Authorised Push Payment fraud (Зөвшөөрөгдсөн шилжүүлгийн залилан)**
Итгэмжлэгдсэн байгууллага (жишээ нь банк) мэтээр хуурч, хохирогчоор өөрийн данс руугаа мөнгө шилжүүлүүлэх залилан.

**Baiting- (Өгөөш)**
Гэмт этгээд уруу татах зүйл санал болгож хохирогчийг хортой файлыг татуулах эсвэл системд нэвтрэх боломж олгох. Үүнд халдварласан дижитал файл эсвэл линк орно.

**Business Email Compromise (Бизнес имэйлийн залилан)**
Бизнесийн имэйл дансанд нэвтэрч, гүйлгээг өөрчилж эсвэл нууц мэдээллийг хулгайлан мөнгө завших хэлбэрийн халдлага.

**Identity fraud (Хувийн мэдээлэл ашиглан хийх залилан)**
Өөр хүн болж жүжиглэх, эсвэл хуурамч нэр, хувийн мэдээлэл ашиглан хуурч мэхлэх.

**Identity theft (Хувийн мэдээлэл хулгайлах)**
Хувийн мэдээллийг хулгайлж, түүнийг ашиглан данс нээх, худалдан авалт хийх гэх мэт гэмт үйлдэл хийх.

**Impersonation (Өөр хүний дүрээр үйлдэх залилан)**
Утас, имэйл, мессежээр өөр хүн эсвэл байгууллага болж хуурч, мөнгө, мэдээлэл авах зорилготой үйлдэл.

**Phishing (Мэхлэх залилан)**
Хуурамч имэйл, мессеж, сошиал медиа дамжуулан хэрэглэгчээс нууц үг, дансны дугаар зэрэг мэдээллийг авах зорилгоор итгэмжлэгдсэн байгууллага мэтээр хуурч мэхлэх.

**Pretexting (мэхэлж мэдээлэл авах)**
Хуурамч нөхцөл байдал үүсгэж, мэдээлэл авах зорилгоор итгэмжлэгдсэн хүн болж жүжиглэх (жишээ нь хамт ажиллагсад, банкны төлөөлөгч).

**Robocall (Автомат дуудлага)**
Урьдчилан бичсэн мессежтэй автомат дуудлага ашиглан залилан хийх. Жишээлбэл, хуурамч санал, төлбөрийн мэдээлэл авах оролдлого.

**SIM Swap fraud (SIM солиулах залилан)**
Гар утасны үйлчилгээ үзүүлэгчийг хуурч, хохирогчийн дугаарыг шинэ SIM карт руу шилжүүлж, түүний дуудлага, мессеж, баталгаажуулалтын кодыг авах.

**Smishing and Vishing (Смишинг ба Вишинг)**
- **Smishing**: SMS ашиглан хувийн мэдээлэл авах оролдлого.
- **Vishing**: Утасны дуудлагаар мэдээлэл авах оролдлого.

**Spear phishing (Тодорхой чиглэлийн фишинг)**
Тодорхой хүн эсвэл байгууллагыг урьдчилан судалж, мэдээлэлд чиглэсэн фишинг халдлага.

**Spoofing (хуурамч дугаар, IP хаяг харуулах)**
IP хаяг, дугаар, имэйл хаяг зэрэг мэдээллийг хуурамчаар өөрчилж, өөр эх сурвалж мэт харагдуулан хуурч мэхлэх.

# ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

## ДЭЛХИЙН БҮС НУТГУУД ДАХЬ САНХҮҮГИЙН ЗАЛИЛАНГИЙН ЧИГ ХАНДЛАГА




*Source: Interpol*

**Интерполын санхүүгийн залилангийн судалгаанд:**

• **Африк, Ази, Латин Америкт:** SIM swap, SIM солих, хувийн мэдээллийг залилах түгээмэл байгаа бол **Европт:** хөрөнгө оруулалтын луйвар, бизнесийн имэйл залилан, романтик залилан, мөн phishing залилан хамгийн түгээмэл халдлагын арга хэвээр байна.

Сошиал инженерчлэлийн залилантай тэмцэхийн тулд **засгийн газрууд, зохицуулагч байгууллагууд** болон мобайл салбар нь хууль эрх зүйн, зохицуулалтын, техникийн болон боловсролын олон **арга хэмжээг хэрэгжүүлж** байна.

# ЗАЛИЛАНГИЙН ЭСРЭГ БОДЛОГО, ЧИГ ХАНДЛАГА

## ЗАЛИЛАНГИЙН ЭСРЭГ ОЛОН ТАЛТ АРГА ХЭМЖЭЭ

**Боловсрол, мэдлэг олгох кампанит ажил**

- Олон нийтийн мэдлэгийг нэмэгдүүлэх, мэдээлэлээр хангах кампанит ажил зохион байгуулж байна.
- Мобайл операторууд ажилчиддаа сургалт явуулж, хэрэглэгчдэд зориулсан хамгаалалтын зөвлөгөөг вебсайтаараа дамжуулан түгээж байна. Жишээ: **UK & Canada:** хэрэглэгчид 7726 дугаараар spam/fraud SMS, дуудлага мэдээлдэг.

**Техникийн арга хэмжээ**

- Firewall хамгаалалт болон баталгаажуулах механизм
- Мэдээллийн аюулгүй байдлын бодлого, системийн **тогтмол хяналт**, тайлан
- SMS Sender ID хамгаалалтын бүртгэл — байгууллагууд өөрсдийн илгээдэг мессежийн гарчгийг бүртгүүлж хамгаалснаар SMS phishing болон spoofing-ийн эрсдлийг бууруулдаг.
- **Салбар хоорондын хамтын ажиллагаа** болон **API** суурьтай шийдлүүд нь банкны болон дижитал залилангийн эсрэг тэмцэх гол арга зам болж байна. Жишээлбэл: **Их Британид** GSMA болон UK Finance хамтран банкууд болон мобайл операторуудын **Scam Signal** шийдэл**, Ази Номхон далай, Латин Америк** зэрэг бүс нутагт операторууд **Open Gateway API** ашиглан банкны залиланг зогсоох боломжийг бүрдүүлжээ.

**Мобайл мөнгөн гүйлгээний залилангийн эсрэг тэмцэл**

GSMA-ийн **“Mobile Money fraud typologies and mitigation strategies”** тайланд мобайл мөнгөний луйврын төрөл, чиг хандлага, луйварчдын арга барил болон урьдчилан сэргийлэх, илрүүлэх, хариу **арга хэмжээ авах стратегийг** тусгасан.

- **Number Verify** –хэрэглэгч зөвхөн бүртгэгдсэн **дугаартай төхөөрөмжөөс хандаж** буй эсэхийг баталгаажуулдаг тул нэмэлт код, нууц үгийн шаардлагагүйгээр найдвартай нэвтрэх боломжийг олгодог.
- **SIM Swap** – SIM карт сүүлд хэзээ **солигдсоныг шалгаж**, сэжигтэй өөрчлөлт илрүүлэн таних нь залилангаас сэргийлнэ.
- **Device Location Verification** –Төхөөрөмж тухайн байршилд байгаа эсэхийг баталгаажуулна.
- **Know Your Customer (KYC)** – хэрэглэгчийн мэдээллийг mobile network-ээр хурдан шалгаж, бүртгэлийг аюулгүй болгодог.

# ЗАЛИЛАНГИЙН ЭСРЭГ БОДЛОГО, ЧИГ ХАНДЛАГА

## ЗАЛИЛАНГИЙН ЭСРЭГ ОЛОН ТАЛТ АРГА ХЭМЖЭЭ

**GSMA Open Gateway-ийн хүрээнд** мобайл операторууд Mobile Connect болон **API-уудыг ашиглан** хэрэглэгчийн баталгаажуулалт, дижитал аюулгүй байдлыг сайжруулж, **онлайн залилангийн эсрэг хамтын ажиллагаа** өрнүүлж байна. Энэ хүрээнд **Малайз, Сингапур, Тайланд** зэрэг орнуудад хамтын ажиллагаа идэвхтэй өрнөж байна.

Дэлхий даяар **операторууд** Number Verification, SIM Swap, KYC Match **стратеги** болон **API**-уудыг нэвтрүүлж, **залилангийн эрсдэлийг бууруулах** чиглэлд ажиллаж байна. **GSMA** нь мөн One Consortium санаачилга болон Mobile Cybersecurity Knowledge Base, FASG, T-ISAC зэрэг платформоор дамжуулан spam, spoofing-ийг бууруулах, мөн fraud/scam-ийн талаарх мэдээлэл**, туршлага, зөвлөмжийг гишүүн операторуудын** хооронд **хуваалцах боломжийг** хангаж байна.

### Хууль эрх зүйн болон зохицуулалтын арга хэмжээ

Дэлхий даяар залилангийн үйл ажиллагааг төрөл бүрийн хууль, зохицуулалтаар шийдвэрлэж байгаа бөгөөд тухайн улсын хууль эрх зүйн орчин харилцан адилгүй байдаг. Зарим улс оронд тусгай хууль батлагдсан байдаг.

- **Их Британи** – *Fraud Act 2006* нь залиланг шууд чиглэсэн гэмт хэрэгт тооцдог;
- **Австрали**-д *Scams Prevention Framework* хэрэгжүүлэх хууль шинээр батлагдаж байгаа бөгөөд энэ нь засгийн газарт банк, харилцаа холбоо, нийгмийн сүлжээ болон мессежийн **үйлчилгээ үзүүлэгч** зэрэг салбаруудыг **“залилангийн өндөр эрсдэлтэй”** гэж ангилж, **тусгай хамгаалалтын зохицуулалт** хэрэгжүүлэх боломж олгож байна.
- Олон улс оронд **KYC шаардлага, гүйлгээний хяналт, хэрэглэгчийн зан төлөвийн шинжилгээ** зэрэг antifraud **системийг** заавал **нэвтрүүл**ж, байгууллагууд хоорондоо **мэдээлэл солилцон хил дамнасан залилангаас сэргийлэхэд** хамтран ажиллаж байна.
- **Австрали** улсад нэвтрүүлж буй **“Scam Code”** нь телеком болон санхүүгийн **байгууллагуудын үүргийг тодорхойлон**, залилан илэрмэгц сэжигтэй дуудлага хаах, данс царцаах зэрэг **шуурхай арга хэмжээ авах** боломжийг бүрдүүлдэг.

# ЗАЛИЛАНГИЙН ЭСРЭГ БОДЛОГО, ЧИГ ХАНДЛАГА

## Дүрэм журам

Олон улсын хууль, тогтолцоонууд уялдаа холбоотой болж, улс орнууд мэдээлэл солилцож, кибер болон залилангийн гэмт хэргийн эсрэг хамтран ажиллах **олон улсын гэрээ, конвенц, хамтын ажиллагааны механизм** бий болгосон

•**Малабо конвенц** нь **Африк тивийн** кибер аюулгүй байдал, мэдээлэл хамгаалалтын нэгдсэн **хууль эрхзүйн тогтолцоог бүрдүүлж**, хувийн мэдээллийн хулгай зэрэг үйлдлийг гэмт хэрэгт тооцдог бөгөөд **15 улс** баталснаар 2023 оны 6-р сард хүчин төгөлдөр болсон.

•АНУ-ын FTC, мөн **Латин Америкийн зарим улс (**Чили, Колумб, Мексик, Перуги)-ийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах байгууллагууд залилангийн эсрэг тусгай механизм бий болгосон.

•**GSMA**-гийн дэмжлэгтэйгээр **Европын зохицуулагч** байгууллагуудын хамтын ажиллагааг хөгжүүлэх зорилготой **GIRAF** (Global Informal Regulatory Antifraud Forum) хэрэгжиж байна.

•**Европын Зөвлөлийн Будапештийн конвенц** нь кибер гэмт хэрэгт олон улсын хамтын ажиллагааны **хууль эрхзүйн суурь** болж, онлайн залилан болон хувилбарлан үйлдэх схемийн мөрдөн шалгалтыг дэмждэг.

•2024 оны 8-р сард **НҮБ** гишүүн орнуудад кибер гэмт хэрэг, залилангийн үйлдлийг гэмт хэрэгт тооцох үүрэг оноосон бөгөөд энэ нь нотлох баримт солилцох, хөрөнгө хураах зэрэг **хил дамнасан хамтын ажиллагааг** шаарддаг.

## Салбар хоорондын хамтын ажиллагаа ба мэдээлэл солилцоо

Залилангийн эсрэг тэмцэлд ганц байгууллага эсвэл салбар дангаараа хангалтгүй тул **салбар хоорондын хамтын ажиллагаа, бодит цагийн өгөгдөл, нөөцөө нэгтгэснээр** залиланг хурдан илрүүлж, таслан зогсоох боломжтой болсон.

•**Их Британи** – Засгийн газар ба томоохон технологийн компаниуд онлайн залилангаас хамгаалах амлалт хийсэн.

•**Австрали** – Anti-Scam Centre байгуулсан.

•**Европ, ASEAN** – санхүүгийн байгууллага, мобайл оператор, хууль сахиулах байгууллагуудын хооронд **хил дамнасан шууд харилцааны суваг** нээсэн.

**Энэтхэг** – DoT операторуудтай хамтран олон улсын spoofing дуудлагыг хэрэглэгчдэд хүрэхээс өмнө блоклодог.

**АНУ** – Robocall хамгийн их гомдлын шалтгаан болж, FCC болон FTC-д олон мянган гомдол үүсгэсэн.

# ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ


Харилцаа холбооны салбар жил бүр ихээхэн хэмжээний **хохирол дагуулдаг** залилангийн асуудалтай тулгардаг бөгөөд үүний дийлэнхийг **дуудлага болон SMS**-ийн харилцан холболтын залилан эзэлдэг.

***GLF FRAUD REPORT 2024*** тайланд, харилцаа холбооны салбар дахь **залилангийн нөхцөл** байдал болон чиг хандлагыг нэгтгэн дүгнэсэн.

Тайланд оролцсон операторуудын бараг **гуравны хоёр** нь залилангийн эсрэг тэмцлийг “**нэн тэргүүний зорилт**” гэж үзжээ.

Тайланд мөн залилангийн эсрэг тэмцэлд салбар хоорондын үр дүнтэй **хамтын ажиллагаа**, мэдээлэл солилцоо болон **нэгдсэн стратеги** боловсруулах нь зайлшгүй чухлыг онцолсон байна.

# ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ




**Гол төрлийн залилан**

- **CLI Spoofing (Caller Line Identification Spoofing)- 55%**

*Утасны дугаарыг хуурамчаар өөрчлөн итгүүлэх залилан*

- **IRSF (International Revenue Share Fraud) -48%**

*Залилагчид өндөр тарифтай олон улсын **тусгай дугаар эзэмшигчидтэй хамтран орлого хуваах зорилготой** залилан үйлдэг.*

- **OBR залилан (Out Bound Refile Fraud)-34%**

*Бодит өртгөөс хямд тарифаар төлбөр тооцоо хийхийн тулд дуудлагын чиглэл, **тарифыг санаатайгаар өөрчилдөг.***

- **Wangiri 2.0 (Call-Back залилан)**–*Залилагч нэг удаа залгаад шууд тасалж, байгууллага эсвэл хэрэглэгчийг өндөр тарифтай дугаар руу буцаан залгуулахад хүргэдэг.*

**PBX хакердах**–Залилагчид байгууллагын дотоод утасны (PBX) системд хууль бусаар нэвтэрч, зөвшөөрөлгүйгээр өндөр тарифтай олон улсын дуудлага хийгдэж, байгууллагад их хэмжээний төлбөрийн хохирол учруулж байна.




***Эрсдэлийг бууруулах шийдэл:***

- *Дуудлагын эх сурвалжийг баталгаажуулах*
- *Бодит цагийн хяналт*
- *Автоматаар блоклох*
- *Хэрэглэгчийн сэрэмжлүүлэг*
- ***Системийн хамгаалалт***
- *Аудитын арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай.*

# ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

## UNWANTED TRAFFIC

### SPAM CALLS LEAD UNWANTED TRAFFIC, OUTPACING ROBO AND PHISHING CALLS

More than 40% of carriers report getting high volumes of nuisance calls, i.e., spam calls, robo calls and phishing calls




**76%**

of carriers say unwanted traffic reduces trust in telecom carriers

**64%**

of carriers say unwanted traffic encourages additional regulatory scrutiny

**58%**

of carriers say unwanted traffic encourages additional regulatory action




Хуурамч ачаалал нь операторын орлого, нэр хүндэд болон зохицуулалтын орчинд эрсдэл дагуулж байна.

- **Итгэл сулруулах** – хэрэглэгчдийн **76%** нь операторт итгэл багассан гэж үзэж байна.
- **OTT рүү шилжих** – хэрэглэгчид Viber, WhatsApp зэрэг рүү шилжиж, орлого буурч байна **(61%).**
- **Хяналт, зохицуулалт нэмэгдэх** – хяналт чангарах (64%) ба шинэ арга хэмжээ авах шаардлага үүсэх (**58%).**
- **Үйлчилгээний ашиглалт буурах** – операторын дуудлага, мессежний хэрэглээ **55%**-иар буурч байна.

# ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ




AIT, Smishing and SMS Originator Spoofing are the biggest threats in terms of volume and financial impact

**62%**

of carriers say they have experienced a 'high' volume of Artificially Inflated Traffic (AIT)

**52%**

of carriers say they have experienced a 'high' volume of SMS phishing (Smishing)

**24%**

of carriers say they have experienced a 'high' volume of SMS Originator Spoofing

FTIDELTA GLF

•Ачааллын түвшин, Операторт үзүүлэх нөлөө , Хэрэглэгчид үзүүлэх нөлөө

**INTERNATIONAL MESSAGING FRAUD**

Мессежийн залилан нь өсөн нэмэгдэж буй асуудал бөгөөд **бизнесийн хувьд чухал энэ сувгийн** аюулгүй байдлыг хангах шаардлага улам бүр нэмэгдэж байна.

Мессеж залилангийн түгээмэл **гурван хэлбэр**:

**AIT (Artificially Inflated Traffic) –62%**

**Зохиомлоор өсгөсөн** мессежийн ачааллаас үүдэн операторуудад их хэмжээний нэмэлт зардал, **санхүүгийн эрсдэл** үүсгэдэг.

**Smishing–52%**

SMS мессеж ашиглан хэрэглэгчийг хуурч хувийн болон санхүүгийн мэдээлэл авах, эсвэл залилангийн **вэбсайт руу чиглүүлж** их хэмжээний **мөнгө** болон хувийн мэдээллээ **алдах**ад хүргэдэг.

**SMS Originator Spoofing– 24%**

Мессеж илгээгчийн нэр эсвэл дугаарыг хууль бусаар өөрчлөн, хүлээн авагчийг итгүүлэх арга. *Жишээ нь, банк, үйлчилгээний компаниас ирсэн мэт харагдана.*

**Шийдэл:** *Эрсдэлийг бууруулахын тулд операторууд **аюулгүй байдлын протокол**, хамгаалалтын шийдлээ тасралтгүй шинэчилж, сайжруулах*

# ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

## THE IMPORTANCE OF FRAUDULENT TRAFFIC IN THE ORGANISATION



2024 онд carrier-уудын **64% нь** хуурамч ачааллын эсрэг тэмцэх нь "Нэн тэргүүний зорилт" гэж үзсэн залилантай тэмцэх зайлшгүй шаардлагатай байгааг харуулж байна.
Операторуудын дурдаж буй **гол шалтгаанууд:**

- Voice traffic, **ашиг буурч буй энэ үед** жижиг залилан ч ихээхэн санхүүгийн эрсдэл дагуулдаг тул урьдчилан сэргийлэх нь чухал.
- **AI, ML** зэрэг дэвшилтэт технологид тулгуурласан шинэ төрлийн залилан уламжлалт илрүүлэх системийн хамгаалалтыг даван гарах болсон тул байгууллагууд илүү хурдан, **уян хатан хамгаалалтын арга** хэмжээг нэвтрүүлэх шаардлагатай болж байна.

Үүний үр дүнд **'Бага ач холбогдолтой'** гэж үзсэн хариултын хувь буурсан







**Операторуудын 88% нь** залилангаас сэргийлэх нь **"Нэн тэргүүний зорилт"** гэж үзэж байна

# ЗАЛИЛАНГИЙН ЭСРЭГ БОДЛОГО, ЧИГ ХАНДЛАГА

## ЗАЛИЛАНГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ОЛОН ТАЛТ САНААЧИЛГА

**Хиймэл оюун ухаан (AI) ба машин сургалтыг (ML) ашиглан бодит цагт залилан илрүүлж, блоклох нь гар ажиллагааг багасгаж, үр ашгийг нэмэгдүүлнэ**

*Хиймэл оюун ухаанд суурилсан аргачлал ашигласан бодит цагийн залилан илрүүлэх системд **хөрөнгө оруулж** байна. Энэ нь гар ажиллагаанд найдахгүйгээр залиланг шууд илрүүлж, бууруулах боломжийг олгодог..*

*Шинэ AI-д суурилсан залилангийн системүүд нь сэжигтэй traffic-ийг илрэнгүүт автоматаар блоклож, сүлжээнд хүрэхээс нь өмнө боломжит хохирлыг **урьдчилан зогсоохоор** бүтээгдсэн.*

**Салбар ба зохицуулагчтай хамтын ажиллагааг өргөжүүлж, мэдээлэл хуваалцсанаар дэлхийн залилан илрүүлэх хүчин чармайлт сайжирна.**

*Салбарын бүлгүүд болон гол түншүүдтэй идэвхтэй **хамтран ажиллаж**, залилан илрүүлэх чадвараа сайжруулж байна. **Өгөгдөл солилцож**, зохицуулагч байгууллагуудтай хамтран ажилласнаар залилангийн удирдлагын стратеги дэлхийн стандартад нийцэж байна.*

*Дэлхийн **форумуудтай** ойр хамтран ажилласнаар гарч буй шинэ төрлийн залилангийн аюулын талаар **мэдээлэлтэй байх** боломжтой болж байна. Энэ мэдлэгийн солилцоо нь илүү сайн бэлтгэлтэй, урьдчилан сэргийлэх хандлагатайгаар залилангийн эсрэг тэмцэхэд тусалж байна.*

**Реактив буюу дараа нь арга хэмжээ авах байдлаас урьдчилан таамаглалт шинжилгээнд суурилсан проактив хандлага руу шилжиж, илрүүлэлтийг ачаалал удирдлагын системд нэгтгэх**

*Идэвхтэй хүчин чармайлт гарган, реактив буюу **дараа нь арга хэмжээ авах хандлагаас** проактив буюу урьдчилан сэргийлэх арга барилд шилжиж, сэжигтэй үйл ажиллагаа **илрэнгүүт** залиланг блоклох дээр төвлөрч байна.*

***Шинэ хэрэгслүүд** (tool), системүүд нь сүлжээнд хүрэхээс нь өмнө залиланг **урьдчилан** таамаглаж, **сэргийлэх**ээр бүтээгдсэн. Залилан илрүүлэлтийг ерөнхий удирдлагад нэгтгэснээр бид санхүүгийн эрсдэл болон залилангаас үүдэх үйл ажиллагааны тасалдлыг бууруулж чадсан.*

Source: GLF Survey 2024.

# ЗАЛИЛАНГИЙН ЭСРЭГ БОДЛОГО, ЧИГ ХАНДЛАГА

## ХУУРАМЧ АЧААЛЛЫН ЭСРЭГ ЗОХИЦУУЛАЛТЫН АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖИШЭЭНҮҮД

Зохицуулагчид хууран мэхлэгчдээс гадна тэднийг зогсоох арга хэмжээ аваагүй телеком оператор, үйлчилгээ үзүүлэгчдэд шууд хариуцлага тооцох болсон бөгөөд хуурамч дуудлага, spam мессеж, өгөгдөл хамгаалалтын зөрчилд ногдуулах торгуулийн хэмжээ сая сая доллар, евро, фунт стерлингт хүрч, тогтмол өссөөр байна.

**Их Британи (2024):** Information Commissioner’s Office (ICO) нь **1.43 сая** хуурамч дуудлага хийсэн байгууллагуудад нийтдээ **£340,000-ын торгууль о**ногдуулжээ.

**Итали (2023):** Италийн зохицуулагч байгууллага **Garante** нь нэгэн мобайл оператор (MNO)-т телемаркетинг болон **robocall** зөрчил гаргасных нь төлөө **7.6 сая еврогийн торгууль** ногдуулжээ..

Энэ оператор нь хэрэглэгчийн өгөгдлийг буруу ашигласан бөгөөд маркетингийн дуудлагад зориулсан зөвшөөрлийг зохих ёсоор удирдаагүй нь **Европын Холбооны Өгөгдөл Хамгаалах Ерөнхий Журам (GDPR)**-ыг зөрчсөнд тооцогдсон байна

**Австрали (2023):**Australian Communications and Media Authority (ACMA) нь телекомын залилангийн эсрэг арга хэмжээгээ эрчимжүүлж, spam-ын эсрэг зохицуулалтыг зөрчсөн хэд хэдэн компанид торгууль ногдуулсан.

Жишээ нь, **Optus** компани нь spam болон robocalls зогсоож чадаагүйн улмаас **500,000 австрали долларын торгууль** хүлээжээ.

**Хятад (2023):** (Ministry of Public Security)-ны хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдийн үр дүнд **2.75 тэрбум** луйврын дуудлага, **2.28** тэрбум сэжигтэй SMS таслан зогсоогдож, **78,000 сэжигтэн** баривчлагдан, **210,000 гаруй хүнд захиргааны шийтгэл** ногдуулсан.

**АНУ (2024):** Federal Communications Commission-(FCC) нь хууль бус robocalls болон мессежийг чиглэсэн шинэ зохицуулалтыг зарласан байна. Шинэ журам нь операторуудаас **хууль бус дуудлагын урсгалыг хаах, VoIP-д хатуу хяналт тавих**ыг шаарддаг. Зөрчил гаргасан тохиолдолд **сая сая ам.долларын торгууль** ногдуулах зохицуулалттай.

# ЗАЛИЛАНГИЙН ЭСРЭГ БОДЛОГО, ЧИГ ХАНДЛАГА

## СИНГАПУР УЛСЫН ANTI-FRAUD ЗОХИЦУУЛАЛТЫН БОДЛОГО, ИНСТИТУЦИЙН АРГА ХЭМЖЭЭ:

**1. Технологид суурилсан хамгаалалт (IMDA-ийн арга хэмжээ)**

- **SMS Sender ID Registry (SSIR)** – зөвшөөрөгдсөн илгээгчийн ID-г албан ёсоор бүртгэж, бүртгэлгүй ID-г автоматаар “Likely-SCAM”-магадлалтай гэж тэмдэглэж анхааруулдаг.
- **Anti-scam фильтр ба блоклох механизм** – URL **(Uniform Resource Locator** буюу интернетийн вэб хаяг) бүхий сэжигтэй SMS, гадаад spoofing дуудлага, хүсээгүй контент бүхий мессежүүдийг шууд хаадаг.
- **SIM хэрэглээний зохицуулалт** – хэрэглэгчид олгох SIM картын тоог хязгаарласан (нэг хэрэглэгчид дээд тал нь 10 postpaid SIM).

Энэ нь **GSMA Open Gateway API +тархсан хамгаалалттай**

**2.Хамтарсан хариуцлагын тогтолцоо-** Shared Responsibility Framework **(SRF)**

2024 онд хэрэгжсэн SRF-ийн дагуу:

- **Банк, төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчид (FIs)** өндөр эрсдэлтэй үйлдэл дээр 12 цагийн cooling-off, real-time мэдэгдэл, “KILL SWITCH” **зогсоох** үйлчилгээ үзүүлэх үүрэгтэй.
- **Операторууд** зөвшөөрөгдөөгүй SMS илгээгчийн ID-г **блоклох**, scam URL-тэй SMS-ийг зогсоох, хэрэглэгчдэд урьдчилан анхааруулах үүрэгтэй.

Ингэснээр **scam-ын хохирлыг зөвхөн нэг тал хүлээх биш, банк ба оператор хамтран хариуцдаг “хамтарсан зохицуулалтын тогтолцоо”** бий болсон.

**3. Хууль эрх зүйн хүрээ**

•**Protection from Scams Bill (2025)** – онлайн болон уламжлалт залилангийн эсрэг шинэ хууль.

- Банк болон үйлчилгээ үзүүлэгчид scam сэжигтэй тохиолдолд **данс царцаах, мөнгө шилжүүлэлтийг зогсоох эрхтэй** болсон.
- **SIM картын буруу хэрэглээг** гэмт хэрэгт тооцдог болсон spoofing, залилан хийсэн тохиолдолд **эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ**.

Энэ нь **технологийн арга хэмжээ + хууль эрх зүйн зохицуулалт** уялдсан загвар юм.

**4. Институци**

- 2019 онд **Anti-Scam Centre** байгуулагдсан.
- 2021 онд **Anti-Scam Division**,
- 2022 онд **Anti-Scam Command (ASCom)** байгуулж, түсгай Scam Strike багууд ажиллаж эхэлсэн.
- Эдгээр нь **цагдаа, банк, телеком салбарын** хамтын ажиллагаатайгаар fraud илрүүлэх, мөрдөн шалгах**, таслан зогсоох үйл ажиллагаа** явуулдаг.

Энэ институцийн зохион байгуулалт нь **салбар хоорондын мэдээлэл солилцооны real-time channel** болж, cross-sector data sharing-ийг хэрэгжүүлж байна.

# ЗАЛИЛАНГИЙН ЭСРЭГ БОДЛОГО БА ШИЙДЛҮҮД

## МАЛАЙЗ УЛСЫН ANTI-FRAUD ЗОХИЦУУЛАЛТЫН БОДЛОГО, ИНСТИТУЦИЙН АРГА ХЭМЖЭЭ:

**1. Технологид суурилсан хамгаалалт**

**Telco Spam/Scam Filtering** – операторуудтай хамтран spam дуудлага, SMS-ийг блоклох системийг хэрэгжүүлсэн.

- **Контент устгал** – 2024 онд л гэхэд 66,507 **scam холбоотой контентыг устгасан**, 2025 оны эхний 2 сарын байдлаар 19,200 нэмэлт контент устгасан.
- **eKYC стандарт** – SIM бүртгэл, хэрэглэгчийн танилтыг хатуу мөрдөж, SIM картаар хийгдэх залилангийн эрсдлийг бууруулж байна.

Энэ нь GSMA Open Gateway-ийн **Number Verification, SIM Swap API**-ийн зарчимтай нийцэж байгаа технологийн хяналт юм.

**2. Салбар хоорондын хамтын ажиллагаа**

- **Securities Commission (SC) + MCMC** хамтарсан ажлын хэсэг (2025) онлайн scam эсрэг зохицуулалт, хэрэгжилт, AI ашиглан **контент устгал** чиглэлээр хүчтэй хамтын ажиллагаа эхлүүлсэн.
- **Bank Negara Malaysia (Төв банк)** болон **харилцаа холбооны** операторууд хамтран **phishing, fake account blocking** зэрэг арга хэмжээг авч байна.

Энэ нь **cross-sector antifraud ecosystem** - салбар хоорондын залилангийн эсрэг экосистем бий болгож байна.

**3. Хууль эрх зүйн хүрээ**

**Communications and Multimedia Act (CMA)** шинэчлэлт (2025):

- Fraud, spam, phishing зэрэг **зөрчлийг Section 233, 233A** дор тусгайлан гэмт хэрэгт тооцсон.
- Spam, unsolicited messages-ийг бүрэн хориглож, зөрчсөн үйлчилгээ үзүүлэгчдэд торгууль ногдуулдаг болсон.
- MCMC-д операторын үйлчилгээ зогсоох, аудит хийх эрх нэмэгдсэн.

**Licensing Guidebook (2025 шинэчлэлт)** – social media, messaging платформууд **(8 саяас дээш хэрэглэгчтэй)** заавал лиценз авах ёстой.Үүнд

- **Fraud, scam эсрэг хяналт, хэрэглэгчийн мэдээллийн хамгаалалт, deepfake/AI content хяналт** зэрэг нөхцөлүүдийг тусгасан.
- Зөрчсөн тохиолдолд ₨500,000 хүртэл торгууль, үйлчилгээ хаах эрхтэй.

Ингэснээр зөвхөн телеком биш, **OTT платформууд ч** хууль эрх зүйн antifraud **зохицуулалтад орсон.**

**4. Институцийн хүчин чадал**

- **MCMC** – телеком ба онлайн платформын үндсэн зохицуулагч.
- **SC (Securities Commission)** – хөрөнгө оруулагч, санхүүгийн салбарт antifraud зохицуулалт хэрэгжүүлдэг.
- **Bank Negara Malaysia** – KYC, eKYC болон санхүүгийн залилангийн хяналт.
- **Royal Malaysia Police (PDRM)** – enforcement болон cross-border мөрдөн шалгалт.

Институцийн хувьд **олон талт (multi-stakeholder) оролцогчидтой antifraud ecosystem** бий болсон.

# ЗАЛИЛАНГИЙН ЭСРЭГ ҮНДЭСНИЙ НЭГДСЭН СИСТЕМ

**National Anti-fraud System (NAS)** нь улс орны хэмжээнд телеком, санхүү, онлайн үйлчилгээ зэрэг олон салбарт үүсч буй **залилан**гийн үйлдлүүдийг илрүүлэх, урьдчилан **сэргийлэх**, зогсоох, мөрдөн шалгах, мэдээлэл солилцох нэгдсэн дэд бүтэц болон зохицуулалтын **цогц систем**ийг хэлнэ.

**NAS-д хамаарах гол оролцогч талууд:**

- ТӨРИЙН ЗОХИЦУУЛАХ БАЙГУУЛЛАГУУД
- ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ОПЕРАТОРУУД
- БАНК БА САНХҮҮГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИД
- ХУУЛЬ САХИУЛАХ БАЙГУУЛЛАГУУД
- ҮНДЭСНИЙ БОЛОН ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГА



# ЗАЛИЛАНГИЙН ЭСРЭГ ҮНДЭСНИЙ НЭГДСЭН СИСТЕМ

## NATIONAL ANTIFRAUD SYSTEM (NAS) -ИЙН ОРОЛЦОГЧ ТАЛУУД:

### ТӨРИЙН ЗОХИЦУУЛАХ БАЙГУУЛЛАГА

•**Харилцаа холбооны зохицуулагч байгууллага, Үндэсний кибер аюулгүй байдлын төв, Санхүүгийн зохицуулагч байгууллага** гэх мэт

***Үүрэг:*** хууль журмыг тогтоох, зохицуулах үүрэгтэй

### ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИД

**Мобайл операторууд** (MNO**), Суурин холбооны операторууд** (FNO), **Интернет үйлчилгээ үзүүлэгчид** (ISP)

***Үүрэг:*** *fraud эрсдлийн удирдлага, real- time бүртгэл, хяналт хийдэг*

### ҮНДЭСНИЙ БОЛОН ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГУУД

**GSMA, ITU, CFCA, i3Forum,** APNI**, Үндэсний байгууллага**

***Үүрэг:*** *Cross-border fraud мэдээлэл, стандарт, best practice хуваалцах*

### БАНК БА САНХҮҮГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИД

**Банк, финтек, төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчид**

***Үүрэг:*** *AML/KYC шалгалт хийх, эрсдлийг хянах, Залилангийн гүйлгээг илрүүлэх, OTP болон SMS banking мэдээлэл хуваалцах*

### ТӨРИЙН ЗОХИЦУУЛАХ БАЙГУУЛЛАГУУД

### ХУУЛЬ САХИУЛАХ БАЙГУУЛЛАГА

•**Цагдаа,Шүүх, прокурор**

***Үүрэг*****:** *Хэрэг шалгах, шийдэх, эрүүгийн болон иргэний хариуцлага хүлээлгэх*

# ЗАЛИЛАНГИЙН ЭСРЭГ ҮНДЭСНИЙ НЭГДСЭН ШИЙДЭЛ

## ANTI-FRAUD STRATEGY




**Anti-Fraud Strategy (залилангийн эсрэг стратеги)**-ийн үндсэн бүрэлдэхүүн:

- **Fraud Prevention (Залилангаас урьдчилан сэргийлэлт)**
- **Fraud Detection (Залилан илрүүлэх)**
- **Fraud Response (Залилангийн эсрэг арга хэмжээ авах)**
- **Fraud Deterrence (Сэрэмжлүүлэх ба айлгах нөлөө)**

Эдгээр стратегиуд дараах **Гадаад хүчин зүйлсээр** дэмжигдэнэ:

- **Legislation (Хууль эрх зүй):** Залилангийн эсрэг хууль, журам.
- **Risk Management (Эрсдэл удирдлага):** Санхүү, үйл ажиллагааны эрсдэлийг тогтмол үнэлж бууруулах.
- **Corporate Governance (Корпорацийн засаглал):** Ил тод, хариуцлагатай байгууллагын засаглал.
- **Ethical Culture (Ёс зүйн соёл):** Ажилтан, хэрэглэгчдийн дунд шударга, ил тод зан үйлийг төлөвшүүлэх.

Дээрх үйл ажиллагаа нэгдэж хэрэгжсэнээр ирээдүйн залилан хийхийг бууруулах, хууль бус оролдлогоос урьдчилан сэргийлэх цогц тогтолцоо бүрддэг.

# ЗАЛИЛАНГИЙН ЭСРЭГ ҮНДЭСНИЙ НЭГДСЭН ШИЙДЭЛ




**Үндсэн бүрэлдэхүүн хэсгүүд:**

**Information Verification (Мэдээлэл баталгаажуулалт)**

- Хэрэглэгчийн имэйл, утасны дугаар, хаягийг шалгаж, итгэмжлэгдсэн мэдээллийн сантай тулган харьцуулна.
- Эрсдэлтэй буюу хуурамч мэдээллийг эрт илрүүлэх зорилготой.

**Document Analysis (Баримт бичгийн шинжилгээ)**

- Иргэний үнэмлэх, паспорт зэрэг баримтын жинхэнэ эсэхийг шалгана.
- Холограм, хамгаалалтын тэмдэг, QR/barcode зэрэг хамгаалалтыг баталгаажуулж, баримт хуурамч эсэхийг тодорхойлдог.

**Facial Recognition (Царай таних технологи)**

- Хэрэглэгчийн зураг болон баримт бичгийн зургыг харьцуулж ижил эсэхийг баталгаажуулна.
- Identity theft (хувийн мэдээллийн хулгай)-ийг багасгахад ашиглагдана.

**Data Validation (Өгөгдөл баталгаажуулалт)**

- Хувийн мэдээллийг (РД, төрсөн огноо гэх мэт) итгэмжлэгдсэн эх сурвалжтай тулган шалгана.
- Зөрүү, зөрчил илэрвэл систем анхааруулга өгнө.

**Geolocation (Байршлын шалгалт)**

- Хэрэглэгчийн байршил бүртгэлтэй хаягтай тохирч байгаа эсэхийг шалгана.
- Хэвийн бус худалдан авалт, үл мэдэгдэх улс/хот дахь гүйлгээг илрүүлнэ.

**Behavioral Monitoring (Зан төлөвийн хяналт)**

- Хэрэглэгчийн худалдан авалтын түүх, төхөөрөмжийн хэрэглээ, гүйлгээний хэв маягийг тасралтгүй хянадаг.
- Хэвийн бус эсвэл сэжигтэй үйлдэл илэрвэл сэрэмжлүүлэг үүсгэнэ.

Энэ систем нь **олон давхар хамгаалалттай anti-fraud экосистем** бөгөөд:

- Мэдээлэл болон баримтын үнэн зөвийг шалгах,
- Хувийн мэдээллийг баталгаажуулах,
- Байршил болон хэрэглэгчийн зан төлөвийг хянах замаар, **залилангийн оролдлогыг эрт илрүүлж, таслан зогсоох** зорилготой.

# ЗАЛИЛАНГИЙН ЭСРЭГ ҮНДЭСНИЙ НЭГДСЭН ШИЙДЭЛ




Энэ процесс нь **өгөгдөл цуглуулах → шинжлэх → дүрэм боловсруулах → холбоосуудыг илрүүлэх → хэрэглэгчийн зан төлөвтэй харьцуулах → баталгаажуулах → амжилтгүй оролдлогыг бүртгэх → сэрэмжлүүлэх** гэсэн **тасралтгүй мөчлөг** юм.

**Fraud Detection Process (Залилан илрүүлэх процесс)**-ийг үе шаттайгаар харуулсан тойрог схем юм.

**Үндсэн үе шатууд:**

**Data Warehousing (Өгөгдөл агуулах)**

- Бүх гүйлгээ, хэрэглэгчийн үйлдэл, системийн лог зэрэг өгөгдлийг цуглуулж, хадгалдаг.

**Analyze (Шинжилгээ хийх)**

- Өгөгдлийг задлан шинжилж, хэвийн болон хэвийн бус зан төлөвийг ялгаж авдаг.

**Creation of Associates Rules (Холбоо дүрэм боловсруулах)**

- Илрүүлэлтийн дүрэм, алгоритм боловсруулна (жишээ нь: тодорхой лимит давсан тохиолдолд сэрэмжлүүлэх).

**Identify Relationships (Холбоос тодорхойлох)**

- Гүйлгээ, хэрэглэгч, төхөөрөмж, байршлын хоорондын хамаарлыг илрүүлнэ.

**If Else Analyzing Patterns (Хэв маягт дүн шинжилгээ хийх)**

- “If-Else” логик ашиглаж, сэжигтэй хэв маягийг автоматаар ангилна.

**Customer Approval Patterns (Хэрэглэгчийн баталгаажуулалтын хэв маяг)**

- Хэрэглэгчийн ердийн үйлдэлтэй харьцуулж, сэжигтэй тохиолдлыг ялгана.

**Customer Authentication (Хэрэглэгчийн баталгаажуулалт)**

- Сэжигтэй гүйлгээ эсвэл үйлдлийг хэрэглэгчээр баталгаажуулах (OTP, KYC **2FA**-Two-Factor Authentication буюу хоёр шатлалтай баталгаажуулалт ).

**Post Failures (Амжилтгүй оролдлогын дараах хяналт)**

- Амжилтгүй болсон гүйлгээ, оролдлогыг бүртгэж, нэмэлт эрсдэл тооцоолол хийнэ.

**Create Alert (Сэрэмжлүүлэг үүсгэх)**

- Илэрсэн залилангийн магадлалтай үйлдлийг албан тушаалтанд мэдэгдэх эсвэл системээр блоклох.

# ЗАЛИЛАНГИЙН ЭСРЭГ ҮНДЭСНИЙ НЭГДСЭН СИСТЕМ

Харилцаа холбоо, санхүү, цахим орчинд тохиолддог залилангийн үйл ажиллагааг илрүүлэх, зогсоох, урьдчилан сэргийлэх зориулалттай **Anti-fraud системийн  түгээмэл хэрэгжүүлэлт:**

### 1. TELECOM ANTI-FRAUD SYSTEM

**Жишээ: GSMA FASG FS.11/FS.19-д суурилсан шийдлүүд**

- **CLI spoofing prevention** – дуудлагын эх сурвалжийг баталгаажуулж, хуурамч дуудлага (caller ID spoofing)-ыг тасалдуулна.
- **SIM box detection** – олон улсын дуудлагыг хууль бусаар орон нутгийн тарифаар дамжуулж буй SIM box-ыг илрүүлнэ.
- **Wangiri 2.0 blocking** – нэг хонх дуугараад тасардаг (callback fraud) залилангаас сэргийлнэ.
- **NRTRDE/TAP3 data analysis** – олон улсын роумингийн real-time дата дээр үндэслэн өндөр эрсдэлтэй хэрэглээг илрүүлнэ.

### 2. BANKING & FINTECH ANTI-FRAUD SYSTEM

**Жишээ: SAS Fraud Management, FICO Falcon, Oracle Financial Crime & Compliance**

- **Transaction Monitoring** – карт, шилжүүлэг, онлайн гүйлгээг real-time шинжилж, сэжигтэй үйлдлийг автоматаар зогсооно.
- **KYC & AML Integration** – хэрэглэгчийн таних баталгаажуулалт (eKYC), мөнгө угаахтай тэмцэх системтэй холбогдоно.
- **Machine Learning Scoring** – хэрэглэгчийн зан төлөвт дүн шинжилгээ хийж, хуурамч гүйлгээг оноогоор илрүүлнэ.

### 3. DIGITAL SERVICES / OTT ANTI-FRAUD

**Жишээ: Meta (Facebook) Security Systems, WhatsApp Fraud Detection, Google Play Protect**

- **Account Takeover Prevention** – OTP, 2FA ашиглан хэрэглэгчийн аккаунт булаах оролдлогоос хамгаална.
- **Spam & Phishing Detection** – AI/ML алгоритмаар мессеж, холбоос дээрх спам болон fishing оролдлогыг хаана.
- **Content Verification** – хэрэглэгчийн нийтлэл, зар, сурталчилгаа хууль бус эсэхийг автоматаар илрүүлнэ.

### 4. HYBRID NATIONAL ANTI-FRAUD PLATFORM

**Жишээ: UK “Scam Signal”, Malaysia’s National Scam Response Center (NSRC),**

- **Central Management Hub** – олон оператор, банк, финтек, төрийн байгууллагаас мэдээлэл цуглуулж, нэг цэгээс удирдана.
- **Cross-Sector Data Exchange** – телеком ↔ банк ↔ хууль сахиулагч байгууллагын хооронд өгөгдөл солилцоно.
- **Public Alerting** – хэрэглэгчдэд real-time scam alert илгээнэ (SMS, app push).

# ЗАЛИЛАНГИЙН ЭСРЭГ ҮНДЭСНИЙ НЭГДСЭН СИСТЕМ

## TELECOM - NATIONAL ANTI-FRAUD SYSTEM




**Үндэсний Anti-Fraud Платформ (NAFP-National Anti-Fraud Platform)**

**Зорилго:** Дуудлага, SMS-ийг холбогдохоос нь өмнө баталгаажуулж, spoof болон залилангийн урсгалыг хаах.

**Ажиллах зарчим:**

- Эх үүсвэрээс дуудлагын мэдээллийг NAFP-д илгээх
- Дуусах оператор баталгаажуулалтын хүсэлт илгээх
- NAFP эх үүсвэр ба дуусах операторын мэдээллийг тулгах
- Зөв бол дуудлагыг зөвшөөрөх, буруу бол залилан гэж тэмдэглэх
- Оператор блоклох, шошгожуулах, шалгах арга хэмжээ авах

**Давуу тал:**

- Бодит цагийн out-of-band баталгаажуулалт
- Жинхэнэ урсгалыг баталгаажуулж false positive-ийг бууруулна
- Сүлжээн дэх итгэлийг сэргээж, хэрэглэгч, оператор, аж ахуйн нэгжийг хамгаална

**Үндэсний түвшинд хэрэгжүүлбэл spoof хийсэн дуудлага, SMS-ийг 100% зогсооно.**

# ЗАЛИЛАНГИЙН ЭСРЭГ ҮНДЭСНИЙ НЭГДСЭН СИСТЕМ

## TELECOM ANTI-FRAUD SYSTEM- AI-Powered Fraud Detection -AB Handshake




**NAFP (National Anti-Fraud Platform) – Хиймэл оюунд суурилсан залилан илрүүлэлт (AI-Powered Fraud Detection)**

**Зорилго:** End-to-End баталгаажуулалтаас зугтах олон улсын болон дотоодын жинхэнэ дугаар ашигласан нарийн залилан илрүүлэх.

**Давуу тал:**

- Илүү ухаалаг (adaptive learning),
- Илүү өргөн (cross-channel),
- Илүү хурдан (real-time at scale),
- Илүү үр дүнтэй (low FPR + fund tracing) байдгаараа онцлог

**Илрүүлэх залилан:** IRSF, Wangiri 2.0, AIT, Smishing/Vishing, PBX hacking, Flash calls, SIM box, CLI spoofing, Spam/Robocall, A2P bypass гэх мэт.

**Интеграц ба өргөтгөх чадвар:** SIP, Diameter, HTTP API, ISUP протоколуудыг дэмжинэ. Legacy-гээс 5G/6G хүртэл нийцтэй. 2–3 сард үндэсний хэмжээнд нэвтрүүлэх боломжтой.

Энэ нь зөвхөн нэг байгууллага бус, бүхэлдээ **үндэсний хэмжээнд интеграцлагдсан antifraud экосистем** болж чаддаг.

## TELECOM ANTI-FRAUD SYSTEM

| Элемент / Шийдэл | Үүрэг / Онцлог |
|---|---|
| Signaling Firewall | SS7 болон Diameter traffic real-time хамгаалалт (+ SIP, GTP-C, HTTP/2) |
| Monitoring & Analytics | Fraud дүн шинжилгээ, alerts, reporting |
| Threat Intelligence Feed | **GSMA FASG-аас ирэх FS.11 / FS.19 хүрээнд шинэ аюулын мэдээллийн удирдлага** |
| Deployment Styles | Inline, Overlay, Integrated загваруудын сонголттой |
| Жишээ Шийдлүүд | Titan.ium, Enea, NetNumber, F5, Mavenir зэрэг industry-leading platform-ууд |

**GSMA-ЫН FS.11 (SS7) БОЛОН FS.19 (DIAMETER)** нь MNO-үүдэд дагах ёстой anti-fraud аргачлалуудыг тогтоож өгдөг бөгөөд эдгээрийн дагуу боловсруулах **FIREWALL АРХИТЕКТУРУУД** нь сүлжээг хамгаалах үндсэн хэлхээ болдог.
Real-time monitoring, cross-protocol correlation, ML-д суурилсан шинжилгээ болон flexible deployment архитектурууд нь өнөөгийн modern мобайл сүлжээний аюулгүй байдлын суурь гэж хэлж болно.

# ЗАЛИЛАНГИЙН ЭСРЭГ ҮНДЭСНИЙ НЭГДСЭН СИСТЕМ

**NETNUMBER Signaling Firewall (TITAN платформ)**

- FS.11 болон FS.19 стандарттай нийцсэн **multi-protocol signaling firewall** шийдэл.
- SS7 болон Diameter траффикт real-time inspection хийж, хортой “UpdateLocation” мессежүүдийг блоконо.
- Carrier-grade бүтэцтэй тул STP/HSS зэрэг гол сүлжээ дотроо inline байршуулдаг







*Figure 1 – NetNumber TITAN Solutions Suite with focus on Security and Fraud Mitigation applications*

**MAVENIR Signaling Firewall**

- FS.11 болон FS.19 стандартад нийцсэн, уламжлалт дүрэмд суурилсан (rule-based) firewall ажиллагаар **машин сургалт (Machine Learning)**-тай хослуулсан ухаалаг хамгаалалтын шийдэл.
- DoS, eavesdrop, SMS interception,location tracking гэх мэт олон төрлийн аюулыг илрүүлдэг




**BROADFORWARD SS7FW болон Diameter Firewall**

•**SS7FW** нь FS.11-ийн ангилалд нийцэх firewall :

- **Velocity check** ашиглаж “time-distance plausibility” хангах (хамгийн хурдацтай байршлын өөрчлөлт)
- “Transparent mode” – шинэ дүрмийг туршиж, алдаагүй баталгаажуулж байж live system-д нэвтрүүлэх.

•**Diameter Firewall (DFW)** нь FS.19-д нийцэх юм:

- Уламжлалт биш, динамик дүрмүүдийг GUI-аар удирдах боломжтой
- SS7FW-тай хослуулан хэрэглэх боломжтой.

# ЗАЛИЛАНГИЙН ЭСРЭГ ҮНДЭСНИЙ НЭГДСЭН СИСТЕМ

## BANKING & FINTECH ANTIFRAUD SYSTEM


**Banking & Fintech Anti-fraud System** нь:

- **Fraud Management (залилангийн илрүүлэлт)**
- **Fraud Framework (салбар бүрт тохирсон шийдэл)**
- **AML (мөнгө угаахтай тэмцэх)**
- **Case Management (хэргийг удирдах ба шалгах)**

гэсэн **дөрвөн үндсэн тулгууртай** бөгөөд банк, финтек болон бусад салбарт залилан, мөнгө угаах эрсдэлийг бууруулах **нэгдсэн antifraud экосистем**ийг бий болгодог.

**SAS-ийн anti-fraud платформ** нь **Integrated Analytics & Case Investigation** буюу **нэгдсэн өгөгдлийн шинжилгээ + кейсийн мөрдөн шалгалт** дээр тулгуурладаг.

# ЗАЛИЛАНГИЙН ЭСРЭГ ҮНДЭСНИЙ НЭГДСЭН СИСТЕМ

## DIGITAL SERVICES / OTT ANTI-FRAUD




Энэ архитектур нь **имэйл, веб, баримт зэрэг олон төрлийн дижитал өгөгдөл дээр anti-fraud илрүүлэлт хийх** процессийг шат дараатайгаар харуулж байна:

- Өгөгдөл цуглуулах →
- AI/ML ба дүрмийн анализ хийх →
- Эрсдэлийн оноо өгөх →
- Хэрэглэгчид аюулгүй өгөгдлийг хүргэх, залилангийн эрсдэлийг устгах.

Энэ схемийг OTT anti-fraud платформд хэрэглэж болох ба **Account Takeover Prevention, Spam/Phishing Detection, Content Verification** модулиудыг  ийм урсгалд тааруулж хөгжүүлдэг.

# ЗАЛИЛАНГИЙН ЭСРЭГ ҮНДЭСНИЙ НЭГДСЭН СИСТЕМ

NAS-ийн архитектур нь **GSMA (телеком fraud API ба мэдээлэл солилцоо) + ITU (сүлжээ, кибер аюулгүй байдал) + ISO (эрсдэл, аюулгүй байдал, авлигын эсрэг, мэдээлэгчийн хамгаалалт)** гэсэн олон улсын **түлхүүр стандартуудын нэгдсэн экосистем** дээр тулгуурладаг.

**GSMA (Mobile & Telecom Fraud Prevention Standards)**

**•GSMA FASG (Fraud and Security Group):**
- CLI spoofing, SMS phishing, IRSF зэрэг телеком залилангийн эсрэг удирдамж.
- Fraud Intelligence Sharing Hub (T-ISAC) – операторуудын хооронд мэдээлэл хуваалцах.

**•GSMA Open Gateway API:**
- **Number Verification** – хэрэглэгчийн дугаарын бодит баталгаажуулалт.
- **SIM Swap Detection** – SIM солилцох залиланг илрүүлэх.
- **KYC Match** – хэрэглэгчийн мэдээллийг баталгаажуулах.

**ITU (International Telecommunication Union Standards)**

**•ITU-T X.805** – Сүлжээний end-to-end аюулгүй байдлын архитектур.
**•ITU-T X.1060** – Ubiquitous networks-ийн аюулгүй байдлын хүрээ.
**•ITU Cybersecurity Guidelines** – cross-border fraud болон кибер гэмт хэргээс хамгаалах удирдамж.
**•CERT Integration** – Үндэсний болон олон улсын CERT-тэй мэдээлэл солилцох тогтолцоо.

